

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ  
ОРЧИНД ДАСАН ЗОХИЦОХ  
ЧАДВАРЫГ ДЭМЖИХ**

**ЗӨВЛӨМЖ**

УЛААНБААТАР

2024

# **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ОРЧИНД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ ЗӨВЛӨМЖ**

Захиалагч: Боловсролын яам

Гүйцэтгэгч: Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

## АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРАНД ХҮҮХДИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ .....	3
Дотуур байранд хүүхдэд тулгарч болзошгүй асуудал .....	4
ХОЁР. ДОТУУР БАЙРНЫ ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ХҮҮХДИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ .....	5
ЗӨВЛӨМЖ.....	5
Дотуур байрны дүрмийг хэрэгжүүлэхэд хүүхэд дасах үйл явцад чиглүүлэх .....	5
Дотуур байрны өдөр тутамд давтагдах үйл ажиллагаанд дасах үйл явцад чиглүүлэх.....	7
Дотуур байрны орчин дахь харилцаа хандлагад дасах үйл явцад чиглүүлэх.....	9
ЗӨВЛӨМЖ.....	9
Хүүхдийн нийгмийн орчинтой харилцах харилцааны дасан зохицох чадварыг дэмжих .....	9
Хүүхдийн багш, ажилтнуудтай харилцах харилцааны дасан зохицох чадварыг дэмжих.....	10
Хүүхдийн үе тэнгийнхэнтэй харилцах харилцааны дасан зохицох чадварыг дэмжих .	11
Өөртөө итгэх итгэлийг нь дэмжих замаар дасан зохицох чадварыг дэмжих.....	13
Идэвхтэй зан чанарыг нь дэмжих .....	14
ГУРАВ. ДОТУУР БАЙРАНД ЗОХИОГДОХ ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ДАМЖУУЛАН ХҮҮХДИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ .....	16
ЗӨВЛӨМЖ.....	17
ДӨРӨВ. БАГШ НЬ ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ, ХАРГАЛЗАН ДЭМЖИГЧТЭЙ ХАМТРАН ХҮҮХДИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ .....	21
ЗӨВЛӨМЖ.....	21
АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....	23

## НЭГ. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРАНД ХҮҮХДИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ

Дотуур байртай сургуулийн бүтэц нь иргэдэд сурч боловсрох эрхээ эдлэх боломжийг нэмэгдүүлдэг төдийгүй шат шатны суралцагчдад амьдралын шинэ хэв маяг, харилцааг бий болгож хувь хүнээс дасан зохицох үйл явцыг шаардана. Суралцагчдын дотуур байранд дасан зохицох үйл явц, тэдний хөгжилд үзүүлэх нөлөө зэргийг судалсан үр дүнгээс харахад, дотуур байранд амьдарсан хугацаа, сургуулийн байршил, суралцагчдын хүйсийн ялгаа зэрэг олон хувьсагчаас хамааран танин мэдэхүй, нийгэмшил, бие бялдрын хөгжилд эерэг болон сөргөөр нөлөөлдөг байна (Yang, P and Yan,Z.Y., 2022). Тухайлбал, суралцагчид дотуур байранд амьдарснаар сурлага нь сайжрах, хичээл таслалт буурах, танин мэдэхүйн чадвар нь сайжрах зэрэг эерэг нөлөөлөлтэй байна. Нөгөөтэйгүүр суралцагчдын харилцаа-сэтгэлийн хөдөлгөөний болон бие бялдрын чадварт сөрөг нөлөө байж болзошгүйг харуулсан судалгааны дүнгүүд ч байна (Kleinfied,D. and Bloom,J., 1977).

Дасан зохицох гэдэг нь орчны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн оюун ухаан, зан байдлын хувьд тэнцвэртэй байдалд хүрэх үйл явц. Харин хүүхдүүдийн хувьд дотуур байранд амьдрахад бэлэн бус байх, эцэг эх, асран хамгаалагчдаасаа хол байхад бэрхшээлтэй тулгарах, дотуур байрны дүрэм журмыг зөрчих, бусадтай нийцгүй байх гэх мэтээр асуудлуудтай тулгардаг. Энэ нь сургуулийн орчин, амьдралын хэв маяг болон хэддүгээр ангид сурч байгаагаас хамаардаг байна (Roskell, 2013). Энэ тохиолдолд хүүхдүүдэд зөвлөгөө, зөвлөмж өгч дэмжих нь дотуур байранд дасан зохицох чадварыг нь сайжруулах, хөгжүүлэх нэг арга болох юм.

Хүүхэд тодорхой хугацаанд гэр бүлээсээ тусдаа амьдрах нь гэрээ санах, шинэ амьдралын хэв маягт дасахгүй байх, олон хүүхэдтэй хамтдаа амьдрах нь харилцааны бэрхшээлийг үүсгэх ялангуяа, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөх үүнээс улбаалан сургууль завсардах, гэр бүлтэйгээ дотно харилцах чадвар буурах, сэтгэл санааны дарамт, гутралд автах зэрэг олон саар үр дагавар үүсэх эрсдэлтэй.

Энэ утгаараа дотуур байранд амьдрах хугацаанд хүүхдийн эрх аюулгүй байдал нь санаатай болон санамсаргүй байдлаар алдагдах учиргүй хамгаалагдсан орчин байх ёстой.

Дотуур байранд гэр бүлээсээ тусдаа байх, түүнчлэн үе тэнгийнхний сөрөг харилцаанаас үүдсэн сэтгэл санааны хувьд таагүй байдгийг цөөнгүй хүүхдүүд дурдсан судалгааны үр дүн байна. Мөн тухайн судалгаагаар дотуур байрандаа мөнгө төгрөгөө алдах, хүүхдүүд бие биедээ нэр хоч өгч шоолох, биесээ цохих гэх мэт үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс гадна, дотуур байрны ажилтны зүгээс таагүй харилцах, хоолны амт чанар, хэмжээ бага байх гэх мэт бэрхшээлүүд байдгийг судалгаанд хамрагдсан хүүхдүүд дурджээ (БСҮХ, ЮНИСЕФ, 2024).

### **Дотуур байранд хүүхдэд тулгарч болзошгүй асуудал**

- Гэр бүлээсээ тусдаа амьдрах нь шаардлагатай халамж анхаарал, асаргааг авч чадахгүй байх
- Гэр бүлээсээ удаан хугацаанд тусдаа амьдарснаар гэр бүлээ санах, дотуур байрны амьдралын хэв маягт дасахгүй байх
- Шаардлагатай хоол тэжээлийг авч чадахгүй байх
- Дотуур байранд бие даан амьдрахад гарч байгаа бэрхшээлээс үүдэн сурах үйлдээ дургүй болох, цаашлаад сургуулиас завсардах, сэтгэл санааны гутралд орох
- Дотуур байранд бие даан хөгжих орчин нөхцөл бүрдээгүй байх, сурлагын хоцрогдолд орох
- Үе тэнгийн дарамт дээрэлхэлтэд өртөх
- Дотуур байрны багш, ажилтнуудтай нээлттэй харилцаж чадахгүй байх, тэдэнтэй харилцааны зөрчилд орох
- Зан төлөвийн хувьд өөртөө итгэлгүй, түрэмгий болох
- Гэр бүлийнхэнтэйгээ нээлттэй дотно харилцах чадвар сулрах
- Гэр бүлийн орчиндоо амьдрах дургүй болох гэх мэт сөрөг үр дагаврууд гарах боломжтой юм.

Эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд сургалтын байгууллага, дотуур байр нь хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн дасан зохицолтыг удирдан чиглүүлэхийг үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх нь үр дүнтэй.

## ХОЁР. ДОТУУР БАЙРНЫ ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ХҮҮХДИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ

Хүрээлэн буй орчны өөрчлөлт, түүний зүгээс тавигдаж байгаа шаардлагад нийцэж зохицох чадварыг дасан зохицох чадвар гэнэ. Дасан зохицох чадвар нь сэтгэц-физиологийн хувьд, гүйцэтгэх үйл ажиллагаа, хүрээлэн буй орчны нөхцөл байдал, хүмүүсийн харилцаа хандлагад дасах үйл явцыг агуулна (Бэгз, Н., Санжаабадам, С., Баярмаа, Б., Энхбаяр, Б., Лхагвасүрэн, Ц., Баярсайхан, Б., Наранцэцэг, Д., Бүрэнжаргал, Г., 2021).

Дотуур байрны өдөр тутмын үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийн дасан зохицох чадварыг дэмжих нь чухал бөгөөд үүнд дотуур байрны орчин, зохион байгуулалт, болон хүүхдүүдтэй харилцах арга барил ихээхэн үүрэгтэй.

[Дасан зохицох чадвар сайтай хүүхдийн онцлог](#)

Зан төлөвийн хувьд идэвхтэй, баяр баясгалантай, айдас түгшүүр багатай, нээлттэй харилцаатай, хичээл, сургалтдаа зорилготой хандах чадвар өндөр.

[Дасан зохицох чадвар хэвийн хүүхдийн онцлог](#)

Байнгын бэрхшээл, түгшүүрт автагддаггүй, бусадтай харилцааны зөрчилд орох нь бага, хичээл сургалтдаа эерэг хандлагатай

[Дасан зохицох чадвар сул хүүхдийн онцлог](#)

Зан төлөвийн хувьд идэвхгүй ноомой, айдас түгшүүрт автагдах нь хялбар, бусадтай нээлттэй идэвхтэй харилцах чадвар сул, бүрэг, хичээл сургалтдаа эерэг хандлага нь сул, бусадтай харилцааны зөрчилд орох нь их, түрэмгий зан авиртай байх, байнгын гомдол мэдүүлэх гэх мэт илрэл ажиглагдаж болно.

## ЗӨВЛӨМЖ

### Дотуур байрны дүрмийг хэрэгжүүлэхэд хүүхэд дасах үйл явцад чиглүүлэх

Дотуур байранд хүүхдийг хүлээж авсны дараа байрны орчин нөхцөл, үйлчилгээний талаар, дотуур байранд ажилладаг багш, ажилтнуудтай нэг бүрчлэн танилцуулж, тэдний гүйцэтгэх үүрэг үйл ажиллагааны талаар нэгдсэн танилцуулгыг зохион байгуулах нь зүйтэй. Үүний зэрэгцээ дотуур байранд үйл ажиллагаа явуулдаг сурагчийн зөвлөл, клубуудын үйл ажиллагааг танилцуулах нь үр дүнтэй юм. Ингэснээр хүүхэд цаашид өөрийн хөгжил, үйл ажиллагааг төлөвлөх, зан төлөвөө дотуур байрны орчинд зохицуулахад ач холбогдолтой байдаг.

Дотуур байранд мөрдөх дотоод дүрэм журмыг хүүхэд эхнээсээ сайтар мөрдөж баримталж сурах нь дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхэд үр дүнтэй. Үүнийг хүүхдүүдэд

дотуур байрны багш нь энгийн үгээр тайлбарлаж ойлгуулах нь чухал. Мөн дотуур байрны дүрэм журмыг хүүхэд, тэрчлэн эцэг эх, асран хамгаалагчид харах боломжтой газар байрлуулвал түүнийг дагаж мөрдөх боломжийг бүрдүүлэхэд сайн нөлөөтэй.

Дотуур байрны дүрэм журмыг баримтлах талаар багш, ажилтнууд хүүхдэд сануулахдаа зааварласан бус аль болох тайлбарлаж ойлгуулсан нөхөрсөг өнгө аясаар харьцах нь харилцааны зөрчлөөс зайлсхийх нэг арга юм. Ялангуяа, шаардлага тавихдаа, эсвэл зөрчсөн тохиолдолд хүүхдийн нэр хүндийг гутаах, биемахбодын шийтгэл үзүүлэх, зандрах, хашгирах гэх мэт хүчирхийллийн хэлбэрээс татгалзах шаардлагатай.

Өөр зайлшгүй анхаарах нэг зүйл бол хүүхэд телевиз, цахим орчинтой зөв зохистой, цагийн хязгаарлалттай хэрэглэх соёлыг төлөвшүүлэх юм.

Хүүхдүүдийг байнга хараа хяналттай байлгахад амаргүй. Хүүхдүүд гарч орох гээд их юм болно. Тэр бүрд арга эвийг нь олох хэрэгтэй болдог. Хоносон жижүүр маргааш нь багшид тайлан тавьж, шаардлагатай бол багштай хамтран арга хэмжээ авна. Болохгүй бол нийгмийн ажилтанд ханддаг. Жишээ нь, ахлах ангийн хүүхэд тамхи татах тохиолдол гарсан, 203 хүүхэд электрон тамхи татсан байсан. Дотуур байрны багш, жижүүр, нийгмийн ажилтан, эцэг эх хамтарч арга хэмжээ авсан. Хүүхдийн хүмүүжил талд байрны багш мэргэжлийн түвшинд хүүхдэд нөлөөлж чадахаар байх хэрэгтэй. Хэт хүүхдийн аяар, зөөлөн байхаар хүүхдүүд чигээ олохгүй байна. Эрэгтэй хүүхдүүд байгаа байранд эрэгтэй багш ажиллах хэрэгтэй байна. Байрны багш тогтвортой байх, хүүхдээ таних хүүхдийн амьдрал ахуйг мэддэг байх хэрэгтэй. Хүүхдийн эцэг эхийн хүмүүжил сул байгаа тул хүүхэд энд ирээд хүмүүжилгүй байна. Дотуур байрны багш нь эцэг эхтэй хамтарч ажиллах чухал ч ихэнх нь малчин тул бэрхшээлтэй байдаг.

*Улаанбаатар хотын дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*  
(БСҮХ, ЮНИСЕФ, 2024)

*Энэ тохиолдолд дотуур байрны багш, ажилтнууд яавал зохистой вэ?*

- ✓ Хүүхэд бүрийг байнгын хараа хяналтад байлгах гэж хичээх нь багш, ажилтны зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөнд сөргөөр нөлөөлөх, цаашлаад сөрөг хандлага бий болгож болзошгүй тул “хараа хяналт” гэдэг дээр хэт анхаарлаа битгий хандуулаарай.
- ✓ Хүүхдүүдийн байрандаа ирэх, гарах цаг хугацааг дүрмээр зохицуулах, хэрэв оройтох, эсвэл гарах шаардлагатай үед хэрхэн, хэнээс зөвшөөрөл авах зэргийг дүрэмдээ тусган, сайтар ойлгуулан дүрмийг баримтлуулахыг хичээгээрэй. Энэ нь эхэндээ бэрхшээлтэй байж болох ч аажимдаа дадал болно.
- ✓ Хүүхдүүдийн зан төлөвийн доголдлыг жишээлбэл, тамхи татах гэх мэт зан үйлийг засан сайжруулахдаа хүүхдийн нэр хүндийг эрхэмлэн, ганцаарчлан зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйч, нийгмийн ажилтанд хандаж мэргэжлийн туслалцаа авах, үе тэнгийнхний дунд нь нэр хүндийг унагаахгүй байх, эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдэгдэх шаардлагатай бол тэдний зүгээс сэтгэл санааны дарамт, хүчирхийлэлд өртөхгүй байх талаас эв дүйтэй хандаарай. Энэ үедээ сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтантай хамтарч ажиллах боломжтой.
- ✓ Хүүхдэд хүндэтгэлтэй хандах гэж хэт хичээхдээ хүүхдийн аяар хандахаас зайлсхийж, ажил хэрэгч харилцааны уур амьсгалыг битгий алдаарай.
- ✓ Хүүхдийг хүмүүжилгүй эсвэл хүмүүжил гэр бүл, эцэг эхээс хамаарсан гэсэн нэр шошгыг хүүхдэд “зүүх” нь нэр хүндэд нь халдсан, ялгаварлан гадуурхсан үйлдэл болохыг санаарай.

## **Дотуур байрны өдөр тутамд давтагдах үйл ажиллагаанд дасах үйл явцад чиглүүлэх**

Дотуур байрны өдөр тутмын амьдралын үйл явц нь гэр бүлийн орчноос нь өөр байдгаас хамааран хүүхдүүдэд бэрхшээл үүсгэж болзошгүй байдаг. Иймд дотуур байрны зүгээс тухайлан шинэ амьдралын хэв маягт нь дасан зохицох үйл явцыг чиглүүлэх хэрэгтэй юм. Ялангуяа, зан төлөвийн хувьд дасан зохицох чадвар сул хүүхдүүдэд энэ нь илүүтэй ажиглагдах тул тухайн хүүхдүүдийг дэмжин ажиллах тал дээр анхаарах нь зүйтэй. Хүүхдүүд хэдийгээр дотуур байрны дүрэм журмыг баримталж байгаа ч амьдралын хэв маягт нь дасан зохицож чадахгүй байгаагаас үүдэн сэтгэц-физиологи, зан үйлийн талаас бэрхшээлтэй байж болох юм. Жишээлбэл: нойрны асуудалд орох, чимээ шуугиантай орчин амарч чадахгүй байх, гэр орноо санах, тэрчлэн айдас түгшүүрт автагдах боломжтой. Үүний нэг шалтгаан нь олуулаа нэг өрөөнд амьдарч байгаа нь бэрхшээлтэй байдаг.

Дотуур байрны өдөр тутмын амьдрал гэдэгт бид дараах зүйлсийг авч үзлээ.

- Унтаж амрах
- Хувцас солих
- Ариун цэвэр сахих
- Хооллох
- Хичээл давтах

Хүүхдийг дотуур байрны өдөр тутмын амьдралд дасан зохицуулахад дараах зан үйлийг баримтлаарай.

### [Унтаж амрах](#)

Хүүхдүүдийн унтаж амрах тав тухыг амьдрах өрөөнд нь бүрдүүлэхийг хичээгээрэй. Тухайлбал, зөөлөн гудас, дулаан хөнжил, цэвэрхэн цагаан хэрэглэлтэй байх гэх мэтээр унтах тав тухтай нөхцөлийг бүрдүүлэх, тасаг бүр нарны гэрэл хаахуйц хөшигтэй байх, унтах үед нь хөшгийг нь татуулж хаалгах, агааржуулалт сайтай, дулаан байх, хүүхдийн тоо нь стандартын дагуу байх, чимээ шуугиангүй байхад өдөр тутамдаа анхаарч ажилласнаар хүүхдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх боломжтой юм.

### [Хувцас солих](#)

Хүүхдүүд өрөөндөө хувцсаа сольж өмсөх орон зай, нөхцөл боломжийг бүрдүүлэх нь амьдарч буй орчин нөхцөлдөө сэтгэл хангалуун байх нэг хүчин зүйл байдаг.

Мөн тухайн боломж бий эсэхийг тогтмол хянаж ажиллах нь чухал. Мөн хүүхэд өрөөндөө өөрийн гэсэн хувцасны шүүгээтэй байх тал дээр сургуулийн удирдлага анхаарах нь чухал байна. Охид, хөвгүүдийн амьдрах өрөө нь тусдаа байх стандартыг баримтлах, өөрөөр хэлбэл, ах, дүүгээрээ нэг өрөөнд амьдрах зайлшгүй шаардлагатай тохиолдолд үүнийг зөрчихгүй байхыг хичээх нь зүйтэй юм.

### [Ариун цэвэр сахих](#)

Хүүхэд бүр гараа тогтмол угаах, шүдээ угаах зан үйлийг хэвшил болгох, ялангуяа, хичээлээс ирээд, хоолонд орохоос өмнө, бие зассаны дараа болон өглөө, оройдоо гараа, шүдээ угаах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд дотур байрны багш ажилтнууд анхаарч ажиллах нь дотуур байранд дасан зохицоход тустайгаас гадна хүүхдийн насан

туршийн хөгжлийг дэмжихэд үр дүнтэй нь эргэлзээгүй. Дотуур байранд хүүхдийн дасан зохицолтыг сайжруулах, амьдрах тав тухыг бий болгоход усанд тогтмол орох боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байдаг. Мөн хүүхэд бүр хувийн ариун цэврийн хэрэгсэлтэй байх, түүнийг байнга сольдог байх тал дээр эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах нь үр дүнтэй.

Ариун цэврийн өрөөг зохистой ашиглах тал дээр хүүхдүүдэд зөвлөн туслах ажлыг тогтмол хийж дадлыг хэвшүүлэх нь үйл ажиллагааны нэг чиглэл байна. “Өсвөр насны охид”-од зориулсан өрөөг тохижуулан охид тогтмол ашиглахыг соёл болгон төлөвшүүлэх нь охидын амьдрах таатай орчныг бүрдүүлэхэд онцгой нөлөөтэй.

Бага ангийн хүүхэд, ялангуяа 6-7 настай хүүхдүүдийн хувцсыг солин усанд оруулах гэх мэт биед нь хүрч асаргаа үзүүлэх тохиолдолд хүүхдэд урьдчилан хэлж зөвшөөрөл авч, аюулгүй мэдрэмжийг нь алдагдуулахгүйгээр эв дүйтэй харилцахад багш, ажилтнууд анхаарах нь хүүхдийн аюулгүй байдалд анхаарал тавьж байгаагийн илрэл юм. Ихэнх хүүхэд ойр дотны хүнээс бусад хүн биед нь хүрч асаргаа үзүүлэхэд айх, түгших байдалд ордог талтай.

Хүүхдүүдийг өрөөндөө гутлаа солих, дулаан углааштай байхыг хэвшил болгож, хөл нүцгэн, эсвэл оймстой байхаас татгалзах нь эрүүл мэндийг нь хамгаалахад чухал байдаг. Мөн дотуур байрны орчинд гадны хувцастай байхыг хориглож, дотуур байрны журамд тусгаж өгөх нь зүйтэй юм.

#### Хооллох

Гадны хүмүүс хүүхдүүдтэй хамтдаа хооллохгүй байх нь зүйтэй юм. Хүүхэд бүрт хоолны шим тэжээлийн талаар ойлголт өгөх, олон төрлийн хоол идэх, ногоо идэх нь өсөлт хөгжилтөд хэрхэн эерэг нөлөө үзүүлэхийг тайлбарлах, тэрчлэн тийм мэдээллийг самбарт байршуулах нь хүүхдүүд дотуур байрны хоолны үйлчилгээнд сэтгэл ханамжтай байхаас гадна цаашид эрүүл хооллох дадал зуршлыг бий болгоход үр дүнтэй байна.

- Хүүхэд хүссэн үедээ цэвэр ус, шингэн зүйл уудаг байхад анхаарах нь зүйтэй.
- Хүүхдүүд хоолны ширээн дээр биеэ хэрхэн зохистой авч байх тал дээр нэгдсэн ойлголт өгч хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй.
- Хоолны үйлчилгээний талаар байнгын санал хүсэлт авч, түүний дагуу хариу арга хэмжээ авч хэвших шаардлагатай.

#### Хичээл давтах

Дотуур байранд хүүхэд хичээлдээ зорилготой хандах чадварыг дэмжин ажиллах нь тэдний танин мэдэхүйн хөгжил, сурлагын амжилтад эерэг нөлөөлөл үзүүлдэг тул хүүхэд хичээлээ давтах, даалгавраа хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй. Жишээлбэл, номын сан, хүүхэд хөгжлийн өрөөнд тав тухтай үйлчилгээ үзүүлэх материаллаг орчин нөхцөлийг бий болгох, боломжоороо хичээл давтах тусгай өрөөг тохижуулах нь үр дүнтэй юм. Аль болох амьдардаг өрөөндөө биш тусгай танхимд хичээлээ давтах, даалгавраа хийх нь үр дүнтэй шүү.

Дотуур байрны хүүхдүүд хичээлээ давтах хуваарьт цагийг албан ёсоор бий болгож мөрдөх нь хичээлдээ зорилготой хандаж сургах гол арга юм.

## Дотуур байрны орчин дахь харилцаа хандлагад дасах үйл явцад чиглүүлэх

Хүүхдийн харилцаа нь 3 хүрээнд явагддаг ба энэ хүрээнд дасан зохицох чадварыг дэмжсэн үйл ажиллагаа явуулах нь чухал. Дотуур байрны орчин дахь харилцаа хандлагад дасан зохицох нийгэм-сэтгэл зүйн чадвар хангалтгүй байгаагаас хүүхдийн сурах хөгжихөд нь бэрхшээл үүсдэг байна. Ялангуяа, дасан зохицох чадвар сул хүүхдүүдтэй багш нар ганцаарчлан ажиллах хэрэгцээ шаардлага тулгардаг.

Нийгмийн орчинтой харилцах харилцаа гэдэг нь дотуур байрны орчин, соёл, хэм хэмжээтэй танилцан хүлээн авах юм.

Хүн хоорондын харилцаа нь хүүхэд ба багш, ажилтан, үе тэнгийн хүүхэд хоорондын харилцаа юм.

Дотоод харилцаа гэдэг нь бие даан амьдрах, бие даан шийдвэр гаргах, бие даан суралцах, өөрийгөө танин мэдэх, зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөнөө удирдан зохицуулахыг хэлнэ.



## ЗӨВЛӨМЖ

### Хүүхдийн нийгмийн орчинтой харилцах харилцааны дасан зохицох чадварыг дэмжих

Дотуур байрны орчинтой танилцуулахдаа баримтлах дүрэм, цагийн хуваарь, өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох, биеэ хэрхэн авч явах талаар танилцуулахаас гадна аюул осол тохиолдоход хэнд хандах, ямар арга хэмжээ авах, өөрийгөө хэрхэн хамгаалах талаар маш сайн ойлгуулна. Энэ талаарх зураглалыг танилцуулан, хүүхэд бүр харах газар байршуулах нь үр дүнтэй.

Дотуур байранд хүүхдүүд хоорондоо нийгмийн харилцаанд ордог тул харилцааны ур чадварыг хөгжүүлэх нь дасан зохицох чадварт тустай.

### *Хүүхдийн багш, ажилтнуудтай харилцах харилцааны дасан зохицох чадварыг дэмжих*


Хүүхдийн ялгаатай, хувийн онцлог, зан төлөвийг ойлгож харилцах нь тэднийг сэтгэл санааны дарамт, хүчирхийлэлд орохоос урьдчилан сэргийлэх гол арга юм.

Хүүхэд бүртэй багш, ажилтнууд эхэлж мэндэлж сураарай. Ингэснээр хүүхдүүд мөн хүндлэх мэндлэх ёсонд суралцана.

Хүүхдэд “Баярлалаа” гэж дотноор хэлж заншаарай. Дотуур байрны багш ажилтнууд, хүүхэдтэй инээмсэглэж харилцдаг, чанга дуугаар хашгирч харилцахгүй байх тал дээр анхаарч ажиллах нь чухал.

**Хүүхдийн алдааг онцлох** нь хүүхэд дотуур байр, сургуулийн орчиндоо айдас түгшүүртэй, илэн далангүй харилцахгүй байх, идэвх оролцоо сул байх, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөх үндэс суурь болдог.

Хүүхдийн алдааг онцлох нь хэл ярианы ба хэл ярианы бус хэлбэртэй байна.



Хүүхдийн гаргаж байгаа алдааг онцлоод байх нь зохимжгүй, алдаа гаргаж байгаа нь тэдний дасан зохицож амжаагүйтэй холбоотой байж болох тул багш, ажилтнууд харилцан ярилцаж, туслалцаа үзүүлэхийг хичээхийг зүйтэй юм.

Хүүхдийг дотуур байрны орчинд ялгаварлан гадуурхсан мэдрэмж төрүүлэхгүй байхад анхаарч ажиллах хэрэгтэй.

Багш ажилтнууд асуулт асуух, заавар зөвлөгөө өгсөн бол ойлгосон эсэхийг нь мэдэж, ойлгоогүй байж магадгүй санагдвал давтан хэлэх нь харилцааны зөрчилд орохоос урьдчилан сэргийлнэ.

Харилцааны улмаас гарах сөрөг үр дагаврыг багш, ажилтнууд тооцож, хүүхэдтэй зүй бус харилцахгүй байхад багш, ажилтнууд анхаарч ажиллах нь зүйтэй. Учир нь зүй бус харилцаа нь хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, сэтгэл зүй, өсөлт хөгжилтөд хортой үр дагавар учруулдаг.

*Хүүхэд байхдаа сэтгэл санааны дарамт хүчирхийллийг мэдэрснээр ичих, өөртөө итгэлгүй болох, шийдвэр гаргахдаа бэрхшээх гэх мэтээр хүүхдийн цаашдын зан чанарт сөргөөр илэрнэ. Хүүхдийн хөдөлгөөнийг утга учиргүй хорих, хэт өндөр шаардлага тавих нь өөртөө итгэлгүй зан төлөвтэй, идэвхгүй, өөрийгөө амархан буруутгадаг зан төлөвтэй болох магадлал маш өндөр (Сэтгэл зүйч Э.Эриксон).*

#### Эерэг харилцаатай багшийн шинж

- Хүүхдийг анхааралтай сонсдог
- Хүүхдийн асуулт, хариулт, даалгаврын гүйцэтгэлд хангалттай цаг хугацаа өгдөг.
- Дахин давтан тайлбарлах ба давтан асуудаг, хариулдаг.
- Хүүхдийг бодитоор урамшуулдаг, магтдаг.
- Хүүхдийн зохисгүйгээр шүүмжилдэггүй, сайн талыг нь олж хардаг.
- Зөв хариулт гүйцэтгэл бүрийг нь урамшуулдаг.
- Олны дунд хүүхдийн сайн талыг нь харуулдаг, алдаршуулдаг.
- Асуултад хариулах боломжийг ямагт олгодог.
- Хүүхэдтэйгээ ойр зайнаас харилцдаг.
- Хүүхэд бүртэй тэгш харилцдаг.
- Дүн үнэлгээ нь шударга
- Хүүхдүүдтэй болон хамт олонтойгоо нөхөрсөг харилцаатай.
- Хүүхдүүдийн амжилт, алдааг нь товч илэрхийлдэг эргэх холбоотой ажилладаг.
- Хүүхдийнхээ нүүр рүү харж харилцдаг, хэл ярианы бус зохистой илэрхийллийг оновчтой хэрэглэдэг.
- Хүүхдүүддээ зааварчилгаа сайн өгдөг.
- Хүүхдүүдийн шинэ санал санаачилгыг дэмждэг, өдөөдөг.

#### **Хүүхдийн үе тэнгийнхэнтэй харилцах харилцааны дасан зохицох чадварыг дэмжих**

Дотуур байрны орчинд хүүхэд ямар нэг байдлаар бие махбод, сэтгэл санааны дарамт, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэнд хандах, тэрчлэн өөрөө үе тэнгийхний дарамтыг үүсгэснээр ямар хариуцлага хүлээх талаар гэрээ, дүрэм журам зэрэгт тусган ажиллаж, ойлгуулах нь зайлошгүй чухал юм.

Үе тэнгийнхний дарамтаас урьдчилан сэргийлсэн зурагт хуудас, танилцуулга, дүрэм журмыг хүүхдийн нүдэнд харагдахуйц газар байрлуулах нь зүйтэй.

Үе тэнгийн болон цахим дээрэлхэлтээс өөрийгөө, найз нөхдөө хамгаалах талаарх сургалт зөвлөгөөний ажлыг мэргэжлийн байгууллага, хүмүүстэй хамтран тогтмол зохион байгуулах талаар үйл ажилллагааны төлөвлөлтдөө тусган хэрэгжүүлдэг байх нь хүүхдэд эерэг зан төлөв, харилцааны дадал бий болгоход чухал нөлөөтэй байдаг.

Үе тэнгийн дээрэлхэлтэд өртөх гэж юу болох талаар, өртсөн тохиолдолд ямар зохистой хариу үйлдэл үзүүлэх талаар ойлголт, зан төлөвийг мэргэжлийн хүмүүс, багш нартай

хамтран олгох нь зүйтэй юм (Ямар ч тохиолдолд үе тэнгийнхний зүгээс үзүүлж байгаа дарамт дээрэлхэлтийг тэвчих нь зохисгүйг хүүхэд бүр ойлгох нь чухал).

Хүүхдүүд дотуур байрны орчинд хувийн эд зүйлээ алдах эрсдэлээс урьдчилан сэргийлсэн орчинг бүрдүүлэх нь дотуур байрны багш, ажилтнуудын нэг үүрэг юм. Үүний тулд жишээлбэл, хүүхдүүд өрөөгөө цоожилж явах боломжтой байх, харагдац нь чанарын шаардлага хангасан камер байруулах, хэрэв алдсан бол яаралтай арга хэмжээ авах зэрэг соёлыг төлөвшүүлэх нь зүйтэй юм.

Хүүхэд бүр дотуур байрандаа бие биеэ хүндэтгэж харилцах, хүндлэх мэндлэх ёсонд суралцах талаар төлөвлөн ажиллах нь зүйтэй.

Хүүхдүүд бие биеэ ялгаварлан гадуурхаж, үл хайхарсан сэтгэл санааны дарамтад оруулж байгаа эсэхэд багш, ажилтнууд анхааран урьдчилан сэргийлж ажилладаг байх нь ач холбогдолтой.

Хүүхдүүд санаатай болон санамсаргүйгээр бие биедээ нэр хоч өгч харилцахаас урьдчилан сэргийлж, хүүхэд бүр бие биеэ нэрээр нь дуудаж харилцах зан үйлийг хэвшүүлэх нь зүйтэй юм. Энэ нь хүүхэд богино хугацаанд дотуур байрны орчинд дасан зохицож сэтгэл ханамжийг нь дээшлүүлэхэд нөлөөтэй.

Дараах асуудалд багш, ажилтнууд анхаарч ажиллах нь хүүхдүүд сургууль, дотуур байрны орчинд дасан зохицоход чухал үүрэгтэй. Үүнд:

- Үе тэнгийнхний дарамтаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн аянуудыг хичээлийн жилийн туршид дотуур байрандаа зохион байгуулдаг байх.
- Хүүхэд амьдралын боломж, өрхийн орлогын ялгаа, эрүүл мэндийн байдал, боловсролын ялгаатай хэрэгцээ зэргээс үүдэн сэтгэл санааны дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтэд орох магадлалтайг санаж ажиллах.
- Багаар ажиллах, бүлгийн үйл ажиллагаанд оролцох, хамтдаа асуудал шийдвэрлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулах.

... Бага байхад бие биеэ дээрэлхэх доромжлох тохиолдол гардаг байсан, тэгээд одоо гайгүй болсон. Ер нь бага хүүхдүүдэд нэлээд тохиолддог, тоглож байгаа хүүхдээ “цаашаа би чамтай тоглохгүй” гээд хэлдэг тал бий. Жижүүр багшдаа заримдаа хэлдэг, багш болохгүй гэж хэлдэг. Өө дээрэлхэх, шоолох зүйл гарна. Одоо энэ байрны хамгийн том нь болохоор надад бол нэг их мэдэгдэхгүй шүү дээ. Хүүхдүүдийг ажиглаж байхад бол гарна тэгээд л хараалын үгс хэлдэг. Тэгээд бие муутай, бие бялдрын хөгжил муутай хүүхдүүдээ дээрэлхэх ч юм уу онцгүй харилцах харагдаж байдаг. Нэр хоч өгөх бол олон гарна. Алгадна, зодно. Камергүй газар очиж байгаад зоддог. Хэн нэгэнд хэлье гэхээр дахиад зодно.

... аймаг, .. сум дотуур байрны хүүхдүүдийн ярилцлагаас

(БСҮХ, ЮНИСЕФ, 2024)

Энэ тохиолдолд анхаарах зүйл:

Дотуур байрны хүүхдүүдэд нас зүйн онцлогт нь тохируулан сургалт, нөлөөллийн ажлыг явуулаарай.

Хүүхдүүд ямар нэгэн үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн тохиолдолд ямар зохистой хариу үйлдэл үзүүлэх, тухайлбал, шаардлага тавих, багшид мэдэгдэх талаар ойлголт, зан үйлийг мэддэг байх хэрэгтэй.

Хэрэв дээрх тохиолдол ажиглагдвал, багш тохиромжтой хариу арга хэмжээ авч, таслан зогсоох үйлдлийг хийдэг байгаарай. Гэхдээ хүчирхийллийн шинж бүхий хүмүүжлийн буруу арга хэрэгслээс зайлсхийх нь чухал. Ямар үед хүүхдийн нэр хүндийг эрхэмлээрэй. Зөвхөн алдаатай үйлдлийг нь ойлгуулж нөлөөлөхийг хичээгээрэй.

Дотуур байрны орчинд хүүхэд хүчирхийллийн алив хэлбэрт өртсөн бол нуун дарагдуулах ёсгүйг хүүхэд бүр ойлгуулахад чиглэсэн нөлөөллийн ажлыг хийх нь зүйтэй юм.

## **Өөртөө итгэх итгэлийг нь дэмжих замаар дасан зохицох чадварыг дэмжих**

Хүүхэд бүртэй хүндэтгэлтэй, найрсаг харилцах нь хүүхдэд “өөрийг нь чухал хүн” гэсэн мэдрэмжийг бий болгодог.

Хүүхэд харилцааны үед айх, ичих, санаа зовох мэдрэмжид автагдахаас ямагт урьдчилан сэргийлж ажиллах ба энэ нь багш, ажилтнуудаас байнгын харилцааны сэрэмж хяналтыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, хүүхдэд хэлж байгаа үг нь болгоомжгүй, сэтгэлийн хөдөлгөөндөө автагдсан, санамсаргүй байх вий гэдгээс багш, ажилтнууд болгоомжлох нь зүйтэй юм.

Дотуур байрны орчинд хүүхдийн асаргаа, халамж хангалттай сайн түвшинд байх шаардлагатай. Жишээлбэл, усанд тогтмол орох, цэвэр хувцаслах, хооллох, цэвэр орчинд амьдрах, гоо сайхандаа анхаарах боломж нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах нь чухал юм.

Хүүхэд ямар нэгэн буруу зүйл хийж байвал түүнийг шууд буруутгаж таслан зогсоохын оронд өөр эерэг зүйлийг санал болгох нь үр дүнтэй байдаг. Жишээлбэл, хүүхэд хог хаяж байвал 2-уулаа энэ хогоо сайхан цэвэрлэе гээд хамтдаа хогийг авч хогийн саванд хийх ч юмуу, эсвэл хэт хөдөлгөөнтэй дүрэм журам баримтлах нь сул бол түүнийг ямар нэгэн

клуб, бүлгийн ахлагчаар тавих, эсвэл нэг чухал даалгаврыг бусадтай хамтран гүйцэтгэх даалгавар өгөх нь зөв зан үйлийг төлөвшүүлэх арга зам юм.

Хүүхдийн сайн талыг урамшуулан магтах нь зүйтэй ч илт хөөргөсөн, хиймэл байхаас зайлсхийх нь өөртөө итгэлтэй зөв зан төлөвийг төлөвшүүлдэг.

Хүүхэдтэй өөрийнх нь эерэг тал, авьяас чадвар, хүсэл мөрөөдөл, түүндээ хүрэх боломжийн талаар багш ярилцдаг бол хүүхэд өөрийн чадвар боломждоо итгэхээс гадна зорилготой болно.

Мөн хүүхдийн гаргасан алдааг ганцаарчлан хэлж өгөх гэхдээ хүндэтгэлтэйгээр буюу хувийн онцлог, зан төлөв, өмнө нь гаргасан алдаа зэргийг нь дурдахгүйгээр зөвхөн гаргасан алдааг нь хэлдэг байх нь зүйтэй. Ингэхдээ алдааг нь хэлсний дараа түүний сайн талыг нь хэлэх нь эерэг зан чанарыг нь бэхжүүлдэг сайн талтай.

---

### *Идэвхтэй зан чанарыг нь дэмжих*

Хүүхэдтэй нээлтэй харилцаж хүүхдийг амжилтад өдөөхдөө тулгараад байгаа бэрхшээлийг нь сонсож тусламж үзүүлэх нь чухал байдаг.

Хүүхдийг цаг баримтлах зан үйлийг хэвшил болгох нь зүйтэй.

Хүүхэд өөрөө шийдвэр гаргах чадварыг нь дэмжих нь идэвхтэй оролцоотой зан чанарыг төлөвшүүлэхэд чухал юм. Ингэхдээ хүүхэдэд зааварлахгүй харин санал тавьж, хэрэв хүүхэд татгалзаж байгаа бол учир шалтгааныг нь асуун ярилцдаг бол эерэг үр дүнтэй.

Хүүхдийг хайрласан аюулгүй тайван мэдрэмжийг багш, ажилтнууд хүүхэдэд төрүүлдэг байх нь өөртөө итгэлтэй тайван, идэвхтэй зан төлөвийг бий болгодог.

Харахад бүрэг ноомой гэмээр сайртсан гар хуруутай хүү ярихдаа: Би сая хоол идээгүй, сургууль дээрээ оройтоод, үдийн хоолноос хоцорсон байна. Гэхдээ өлссөн ч тэснэ дээ, орой хоолоо иднэ, би угаасаа багаасаа эхлээд өлсөхийг сурчихсан юм... Манай байрны багш өглөө хичээлгүй байсан ч чанга дуугаар 6.30 гээд босгоно, тэгээд цайгаа ууна, хэрэв сэрэхгүй бол хүйтэн ус цацна... Миний гарыг багш тамхины асаагуураар түлсэн, хүүхдийн мөнгө алдагдахаар авсан уу гээд тэгж шийтгэдэг юм. Ээж аавд хэлсэн ч эр хүн байж гээд тоодоггүй. Цэцэрлэгт байхад ч багш намайг загнаж зодсон ч аав ээж тоодоггүй .... аав ээж маань малчин тул над дээр ховорхон ирдэг. Түүний царай ядрангүй, асрамж халамж тааруухан байдалтай.

*Сумын сургуулийн дотуур байранд амьдардаг  
2-р ангийн хүүгийн ярианаас*

**Энэ тохиолдолд өгөх зөвлөгөө:**

- Хүүхэд наснаасаа үл хайхралд өртөх нь хүүхдэд өөртөө итгэлгүй, анхаарал муутай, бусдыг аялдан дагалдсан зан төлөвтэй, орхигдсон мэдрэмжийг төрүүлдэг.
- Амьдралын нөхцөл байдал, хувийн зан төлөв зэргээс хамааран эцэг эх, асран хамгаалагчид хүүхэд хамгааллын мэдлэг хангалтгүй тул үе шаттай сургалт зөвлөгөөг өгч ажиллаарай.
- Багш, ажилтнууд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах мэдлэг, чадвартай байх нь чухал.
- Хүүхэд бүрд анхаарал халамж тавьдаг орчныг бүрдүүлээрэй.
- Хүүхдийн унтах, босоход цагийн хуваарийг сайтар мөрдөөрэй.
- Хүүхэд хүссэн үедээ тасагтаа амрах унтах боломжийг олгодог байгаарай.
- Өглөө хүүхдийг сэрээхдээ хүчирхийлэл дарамт бүү үзүүлээрэй.

## ГУРАВ. ДОТУУР БАЙРАНД ЗОХИОГДОХ ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ДАМЖУУЛАН ХҮҮХДИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ

Хүүхдийн хөгжлийг бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн бүрэлдэхүүнд авч үздэг ба хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа нь хүүхдийн цогц хөгжлийг дэмжих зорилготой байна.

Хүүхэд үйл ажиллагааны оролцоо идэвхтэй байх нь дотуур байрны орчинд дасан зохицоход чухал түлхэц болдог. Эсрэгээрээ, үйл ажиллагааны идэвх, оролцоо сул байх нь зан төлөвийн төлөвшил, харилцаа, сэтгэлийн хөдөлгөөний чадвар, өөрийн ойлголт, үнэлэмж зэрэгт нь сөргөөр нөлөөлөн цаашилбал, сургуульд дургүйцэх сурлагын хоцрогдол гэх мэт зан үйлийг бий болгодог. Иймд үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийн дасан зохицолтыг удирдах нь чухал юм.



## ЗӨВЛӨМЖ

Сургуулийн удирдлагын зүгээс дотуур байрны багшийг хүүхдийн дунд хөгжлийн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах тал дээр чадавхжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь мэргэжил арга зүйн удирдлагын нэг хэсэг юм.

*Хүүхэд хөгжлийн төлөвлөгөөтэй байна*

- Дотуур байрны хүүхэд хөгжлийн төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд боловсруулан хүүхэд бүрд албан ёсоор танилцуулдаг байх нь зүйтэй.
- Дотуур байрны хүүхэд хөгжлийн төлөвлөгөөг харагдахуйц газар байршуулна.
- Дотуур байрны хүүхэд хөгжлийн төлөвлөгөө нь хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн чадварыг дэмжих бүтэцтэй байна.
- Дотуур байрны хүүхэд хөгжлийн төлөвлөгөөнд туссан ажил бүр нь өөрийн гэсэн зорилго, зорилт, үйл ажиллагаа, оролцогч талууд, үр дүн зэргийг тусгасан удирдамжтай байна.
- Дотуур байрны багш хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны талаар хавтастай байна.
- Дотуур байрны хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа нь олон талын оролцоог хангасан байх нь зүйтэй (орон нутгийн мэргэжлийн байгууллага, төрийн байгууллага, сурагчдын бие даасан клуб гэх мэт).
- Зохиогдсон үйл ажиллагааны талаар хүүхдүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг нь тооцдог байх нь чухал.
- Хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа хүүхдийн саналыг тусгах нь үр дүнтэй.

*Хүүхдийн бие бялдарын хөгжлийг дэмжих хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа*

Хүүхэд бие бялдарын хөгжил сайтай байх нь өөрийгөө эерэгээр үнэлэх, өөртөө сэтгэл ханамжтай байх, зорилго эрмэлзлэлтэй, нөхөрсөг, идэвхтэй, тэсвэр тэвчээртэй, бусадтай нийцтэй гэх мэт олон эерэг зан чанарыг төлөвшүүлдэг. Иймд дотуур байрны орчин хүүхэд бие бялдраа хөгжүүлэх орчинг бүрдүүлсэн байх нь чухал юм. Үүнд:

- Дотуур байрандаа хүүхдүүд өглөө тогтмол дасгал хөдөлгөөн хийж хэвших;
- Хүүхдүүд дотуур байрны гадаад талбайдаа спорт тоглоом тоглох, гүйх боломжийг бүрдүүлэх;
- Хүүхдийн өсөлт хөгжлийг сургууль дотуур байрны эмчтэй хамтран улирал бүр хэмжилт хийж үнэлэх, түүний дагуу зорилтот үйл ажиллагаа явуулж үр дүнг нь тооцдог байх;
- Дотуур байрны орчинд дасгал хөдөлгөөн хийх техник хэрэгсэл бүхий өрөө тасалгааг тохижуулах;
- Дотуур байрны хүүхдүүдийг биеийн тамирын секц, дугуйланд жигд хамруулах тал дээр сургуулийн удирдлага, эцэг эхтэй хамтран санаачилгатай ажиллах;
- Дотуур байрны хүүхдүүдийн дунд спортын уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулж хүүхэд бүрийн оролцоог дэмжин ажиллах;
- Дотуур байрны хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжсэн хоол тэжээлийн тал дээр судалгаатай ажиллах.

---

Дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн биеийн өндөр нь гэртээ амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад, 1-2 см-ээр намхан, бүсэлхийн тойрог нь 1-2 см-ээр их байна. Гэтэл биеийн уян хатан, хүч, хурдны чанар нь статистик ач холбогдлын түвшинд илүү байна (БСҮХ, 2021).

---

#### Хүүхдийн нийгэмшлийн чадварыг дэмжих хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа

Дотуур байрны хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны нэг зорилго нь хүүхдийн өөртөө итгэх итгэл, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, бусадтай нээлттэй харилцах, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох, хамтрах, сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ. Үүний тулд:

- Дотуур байранд бие даасан клубын тоо, төрлийг нэмэгдүүлэх нь чухал. Зөвхөн сурагчийн зөвлөл, охид, хөвгүүдийн клуб, номын клуб гэсэн төрлөөр хязгаарлагдахгүй олон төрөл байхад анхаарах. Жишээлбэл, гитар тоглодог хүүхдүүдийн клуб байж болох юм. Энд хүүхдүүд гитар тоглохоос гадна бусад хүүхдүүдэд зааж сургах үйл ажиллагаа явуулах боломжтой.
- Бие даасан зөвлөл, клубуудын удирдах зөвлөл, ахлагчийг санал авч сонгодог зарчмаар ажиллах.
- Бие даасан клуб, зөвлөл бүрийн үйл ажиллагааг хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулах.
- Бие даасан клуб, зөвлөлийн үйл ажиллагаа нь байнгын, тогтмол ажиллагаатай байх, гэхдээ зөвхөн сурагчийн зөвлөл нь дүрэм журам сахиулах, номын клуб нь хүүхдэд ном тарааж өгөх, хурааж авах гэх мэт идэвхгүй үйл ажиллагаатай биш, хүүхдийн манлайлал, зохион байгуулах, харилцах, шийдвэр гаргах, өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн байх нь үр дүнтэй.
- Бие даасан клуб, зөвлөлийн үйл ажиллагаа нь сайн дурын шинжтэй байхаас гадна хүүхдийн өөрөө удирдах зарчимд тулгуурласан байна.
- Дотуур байранд сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, сургуулийн эмч болон бусад мэргэжлийн байгууллага, хувь хүнтэй хамтран сургалт, зөвлөгөөг тогтмол зохион байгуулах.
- Дотуур байрны хүүхдүүдэд хөдөлмөрийн дадал, мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн секц, дугуйлан, сургалт зөвлөгөөг тасралтгүй явуулах.
- Хүүхдийн бүтээлийг сурталчлах, хүүхдүүд бие биедээ сурсан мэдсэнээ зааж сургах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах нь үр дүнтэй.
- Дотуур байрны хүүхдүүдийн дунд урлаг, соёлын арга хэмжээг тогтмол хийж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх үйл ажиллагааг сонирхолтой, өвөрмөц шинэлэг байдлаар зохион байгуулах.

---

Дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, идэвхтэй зан төлөв нь гэртээ амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад бага зэрэг сул байна. Жишээлбэл, идэвхтэй зан төлөвийн хувьд, гэртээ амьдардаг хүүхдүүдийн 27.0 хувь нь маш идэвхтэй түвшинд байхад, дотуур байрны хүүхдүүдийн 16.0 хувь тийм түвшинд байх жишээтэй. Харин өөртөө итгэлтэй зан төлөвийн хувьд, гэртээ амьдардаг хүүхдүүдийн 56.0 хувь нь сайн байхад дотуур байрны хүүхдийн 52.0 хувь нь тухайн түвшинд байна (БСҮХ, 2021).

---

Хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийг дэмжих хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа

Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих орчин нь дотуур байрны номын сан, хүүхэд хөгжлийн өрөө юм. Материаллаг орчны хангамж сайн байх нь хүүхэд дотуур байрны амьдралын хэв маягт дасан зохицоход чухал түлхэц болдог. Үүний тулд:

- Дотуур байрны номын сан, хүүхэд хөгжлийн өрөө нь номын фонд, тоглоом хэрэгсэл сайтай, түүнийг байнга баяжуулдаг байх тал дээр сургуулийн удирдлагатай хамтран санаачилгатай ажиллах;
- Дотуур байранд хүүхдүүдийн ном унших дадлыг хөгжүүлсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах нь танин мэдэхүйн хөгжилд чухал ач холбогдолтой.
- Уншсан номын дагуу жүжигчилсэн тоглолт хийх зэргээр хүүхдийн сонирхлыг төрүүлсэн байдлаар бусдад таниулан сурталчлах арга хэмжээг зохион байгуулах нь уншаад ойлгох, дүрслэх, хэл ярианы илэрхийлэх чадварыг хөгжүүлэх ач холбогдолтой.
- Дотуур байрны орчинд хүүхэд цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх тал дээр цагийн менежментэй ажиллаж хэвших;
- Хүүхэд бие даан хичээлээ давтах, нэмэлт мэдээлэл олж авах, бие биеэсээ суралцдаг байх нь хичээлдээ зорилготой хандах чадварыг хөгжүүлж, танин мэдэхүйн чадварт эерэг нөлөөтэй.
- Алив асуудлаар бие биетэйгээ санал солилцох, хэлэлцэх, шийдвэр гаргах үйл ажиллагааг тогтмолжуулснаар үзэгдэл юмсыг учир шалтгаанд нь сэтгэх чадварыг сайжруулна.
- Дотуур байрны хүүхдүүдэд судлагдахууны багш нар давтлага өгөх, туслах үйл ажиллагааг сургуулийн зүгээс албан ёсоор зохицуулалт хийх;
- Энэ тал дээр дотуур байрны багш, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид хамтран ажиллах нь зүйтэй.

“Дотуур байранд ямар үйл ажиллагаа зохиогддог байгаасай гэж хүсэж байна вэ?” гэсэн асуултад дотуур байрны хүүхдүүд бүжиг, уран зураг, ярих чадвар, англи хэлний, гар урлал, хөгжмийн, бусадтай зөв харилцах чадвар, төрөл бүрийн спортын секц дугуйлан хичээллүүлэх талаар саналаа хэлжээ.

“Том болж байгаа учраас хүнтэй зөв харилцахад хэрэгтэй “ярих чадвар”-ыг сайжруулах дугуйлан хичээллэвэл илүү үр дүнтэй байх гэж бодож байна”.

*.. аймаг, ... сумын ЕБС-ийн дотуур байрны 14 настай хүүхэдтэй хийсэн ярилцлагаас*

“Ажил, мэргэжилтэй холбоотой сургалт, өдөрлөг зохион байгуулах, алдартай хүмүүстэй уулзах гэх мэт ажил зохиогдвол сонирхолтой байна. “

*... аймгийн ... сум, дотуур байрны 15 настай хүүхдийн ярилцлагаас  
(БСҮХ, ЮНИСЕФ, 2024)*

### **Зөвлөгөө**

Дотуур байранд зохиогдох хүүхэд хөгжлийн үйл ажиллагаанд хүүхдүүдийн саналыг авдаг байгаарай.

Хүүхдүүдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрийн дадал олгох үйл ажиллагааг зохион байгуулахдаа сургуулийн тогооч, үйлчлэгч гэх мэт хүмүүсийн оролцоог хангаж ажиллах тал дээр сургуулийн удирдлагатай хамтран ажиллах нь үр дүнтэй.

Нэр хүндтэй, туршлагатай хүмүүстэй хүүхдүүд уулзах, ярилцах үйл ажиллагааг зохион байгуулж хэвшээрэй.

---

Дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн богино хугацаанд мэдээллийг харж тогтоох чадвар, сонсож тогтоох чадвар нь, өгүүлбэрээр санаа бодлоо ярих чадвар нь харьцангуй сайн байна. Гэртээ амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад, дотуур байрны хүүхдүүдийн юмсыг анхааралтай ажиглах, бүхэлд нь хүртэж ойлгох, ярих чадвар, үгийг утгаар нь ангилах чадвар нь статистик ялгаатай түвшинд бага зэрэг сул байна ( $p < 0.05$ ).

Дотуур байрны хүүхдүүдийн математик сэтгэхүй, сэтгэхүйн ангилах чадвар, үгийн утгыг ойлгох, санаа бодлоо дүгнэж ярих чадварыг нь дэмжих нь зүйтэй байна (БСҮХ, 2021).

---

## **ДӨРӨВ. БАГШ НЬ ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ, ХАРГАЛЗАН ДЭМЖИГЧТЭЙ ХАМТРАН ХҮҮХДИЙН ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ**

Хүүхдийг амьдралд бэлтгэх зорилгынхоо хүрээнд боловсролын салбар нь нийгэм, суралцагчдад төдийгүй эцэг эхчүүдэд хүлээлтийг бий болгодог. Хүлээлтийг хангаж чадаж байна уу, үгүй юу гэдгээр боловсролын чанарыг хэмжиж болдог. Иймд суралцагчийн эцэг эхийн хэрэгцээ, хүлээлтэд уялдсан боловсролын үйлчилгээ, чанар, үр дүнг бий болох нь салбарын нэг асуудал юм. Хэдийгээр хүүхэд анги дэвших тусам эцэг эхийн шууд оролцоо багасдаг хэдий ч тэдний зохистой оролцоо нь ялангуяа өсвөр насанд сургуулийн орчинд дасан зохицоход үр нөлөөтэй байна.

Эцэг эхчүүдийн зөвхөн оролцох үйл биш, оролцооны хандлага нөлөөлөх гол хүчин зүйл байдаг. Тэдний оролцооны эерэг хандлага, үүрэг хариуцлагатай мэдрэмж, сайн дурын идэвх оролцоо нь чухал шалгуур байдаг.

Хүүхдийн дасан зохицох чадварыг дэмжихдээ сургууль-эцэг эхийн хамтын ажиллагааг бий болгох гаргалгаа нь нэгдүгээрт, сургууль ангийн үйл ажиллагаанд эцэг эхийн дуу хоолойг сонсох, хоёрдугаарт, эцэг эх хүүхэд хоорондын харилцаа хандлагыг сайжруулахад зөвлөн туслах, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх юм.

### **ЗӨВЛӨМЖ**

Дотуур байранд анх хүүхэд ороход эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нартай хийх гэрээнд үүрэг хариуцлага, эрхийг нь нарийн тодорхой тусгаж өгч танилцуулж гарын үсэг зуруулна.

Сургууль, дотуур байрны үйл ажиллагаа, үйлчилгээний талаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд таниулан сурталчлах үйл ажиллагааг захидал бичих, өдөрлөг зохион байгуулах гэх мэтээр зохион байгуулах аргуудаас хэрэгжүүлж болох юм.

Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнд нь тулгуурлан үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг байх нь зүйтэй юм.

Дотуур байранд олон ажил зохион байгуулдаг, гэхдээ уралдаан тэмцээн, урлагийн үзлэг, наадам, шинэ жилийн баяр, шүлгийн уралдаан, тэмцээн, бүжиг, шагай, шатар, даамны тэмцээнд оролцдог талаар нь заримдаа хүүхдийнхээ ярианаас сонсдог ба эцэг эхэд тийм тийм ажил зохион байгуулна гэж мэдээлэл өгдөггүй. Мөн хүүхдүүд нь ямар ажилд оролцох тухайгаа эцэг эх, асран хамгаалагчдадаа тэр бүр бас яриад байдаггүй буюу хааяа асуухаар тодорхой юм хариулдаггүй гэж эцэг эхчүүдийн ярилцлагад дурдагджээ (БСҮХ, ЮНИСЕФ, 2024).

Энэ тохиолдолд өгөх зөвлөгөө:

- Хичээлийн жилийн эхэнд дотуур байранд зохиогдох хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа хүүхэд, эцэг, эх асран хамгаалагч, орон нутгийн мэргэжлийн байгууллагын санал авч, төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагчдад урьдчилан танилцуулдаг байх, мөн төлөвлөгөөгөө мэдээллийн самбар, эцэг эхийн уулзалтын өрөө зэрэгт байрлуулж хэвшээрэй.
- Хичээлийн жилийн тухайн улирал, сард зохиогдох үйл ажиллагааны талаарх мэдээллийг эцэг эх, асран хамгаалагчдад мэдэгдэж хэвшээрэй.
- Хүүхдийн гаргасан амжилтыг эцэг эх, асран хамгаалагчдад мэдэгдэж баяр хүргэж хэвшээрэй.

Хүүхдээ хэрхэн хөгжүүлэх хэрэгцээ, хүсэл эрмэлзлийнх нь талаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн “дуу хоолой”-г сонсож ажиллах нь тэдэнтэй хамтран ажиллах нэг арга юм.

Дотуур байрны хүүхэд нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэйгээ уулзах, цагийг өнгөрөөх тухтай аюулгүй орчинг бүрдүүлснээр хүүхдүүд гэр бүлийнхэнтэйгээ эерэг харилцааг бэхжүүлэх, дотуур байрандаа эцэг эхээ санахгүй байх зэрэг олон ач холбогдолтой. Энэ үедээ эцэг эхчүүд хүүхдийнхээ амьдардаг өрөөтэй танилцах боломжийг олгох нь зүйтэй.

Дотуур байрны хүүхдийнх нь хөгжил төлөвшил, сэтгэл санааны байдал, сурлагын ахиц амжилтын талаарх мэдээллийг эцэг эхэд нь тогтмол өгдөг байх нь хүүхдийн сурлагыг дэмжиж ажилалх боломжийг бүрдүүлэх юм.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Kleinfield, D. and Bloom, J. (1977). *Boarding schools: effects on the mental health of eskimo adolescents. Am. J. Psychiatry.*
- Yang, P and Yan, Z.Y. (2022). *How boarding schools affect student mental health? J. East. China.*
- БСҮХ, ЮНИСЕФ. (2024). *Дотуур байрны өнөөгийн байдал, хүчин чадлыг тодорхойлох судалгаа.*
- Бэгз, Н., Санжаабадам, С., Баярмаа, Б., Энхбаяр, Б., Лхагвасүрэн, Ц., Баярсайхан, Б., Наранцэцэг, Д., Бүрэнжаргал, Г. (2021). *Нэр томъёоны тайлбар толь: Хүний хөгжил.* Улаанбаатар: Соёмбо Принтинг.